

XX зууны 30-аад оны үеийн хэлмэгдүүлэлт- С.Наваан-Юндэнгийн байцаалтын протоколд хийсэн судалгааны ажиглалт

Сүлдэт Р. Төрдалай
МУИС-ийн Монгол судлалын төвийн судлаач

1926-1930-иад онд Герман, Францад суралцсан Монголын оюутан, сурагчдын түүхийг мөшгин судлах явцад¹ тэднийг хожим улс төрийн хилс хэрэгт холбогдуулж хэлмэгдүүлсэн талаар анхааран судлах бодол төрсөн билээ. Учир нь тэдгээр залуусын хилсээр хэлмэгдсэн талаар намтар судлалын чиглэлээр хэвлэгдсэн зарим бүтээл, сонины тухайлсан хөрөг найруулал зэрэгт цухас дурьдсныг эс тооцвол өнөөг хүртэл тун бага судалжээ.

Баруун Европын соёл, боловсролыг Монголд анх тээн авчирсан тэдгээр залуусын хожмын амьдралын түүхийг мөшгин тодруулах нь судлаачийн хувийн сонирхлоос илүү түүхэн ач холбогдолтой асуудал бөгөөд эл өгүүллийг бичигч энэ удаа С.Наваан-Юндэнг “Герман тагнуулын хэрэг”-т холбогдуулж хэлмэгдүүлсэн тухайд анхаарлаа хандуулсан болно.

С.Наваан-Юндэнгийн амьдралын түүх

С.Наваан-Юндэн нь Манж Чин Улсын Бадаргуулт төрийн 34-р оны шар бичин жил буюу Европын 1908 онд Түшээт хан аймгийн нутаг (Төв аймгийн Батсүмбэр сум)^{*} Өлгий хэмээх газар хошууны угсаа залгамжилсан засаг ноён Содномдаржаагийн төрсөн дүү Насан-Очирын хөвгүүн болон төржээ.² Тэрээр 1913 онд 5 настайдаа өргөмөл эцэг засаг ноён Содномдаржаагийн хэргэм, зэргийг залгамжилж 1921 он хүртэл Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны засаг ноён суусан

¹ Сүлдэт Р.Төрдалай, *Монгол-Германы соёл, боловсролын харилцаа: Монгол оюутан, сурагчид Герман улсад суралцсан нь (1926-1930), Герман: Судалгаа, мэдээлэл, УБ, 1(3) 2004, 78-160-р тал*

^{*} С.Наваан-Юндэнгээс 1940 оны XI сарын 15-нд өгч байсан мэдүүлэгтээ Төв аймгийн Батсүмбэр суманд төрсөн гэж дурьджээ. Энэ нь өнөөгийн Сэлэнгэ аймгийн Мандал сум юм. /Р. Т./

² Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж - Ц 422 I - Ц, 112-р тал

байна. 1923-1926 онд Ардын Засгийн анхны дунд сургууль, 1926-1927 онд БНМАУ-ын Засгийн Газраас Герман улсын Пруссийн Боловсролын яамтай хийсэн хэлэлцээрийн дагуу Берлин хотын Лихтерфельде дүүрэгт орших Улсын Сургалтын байгууллагын (Staatliche Lehranstalt in Lichterfelde) дунд сургууль, мөн Потсдам хотын дунд сургуульд шилжин суралцаж байсны зэрэгцээ хэвлэлийн арга ажиллагаанд суралцан үйлдвэрт тусгай дадлагын ажил хийн манай улсын Засгийн газрын зохистой төлөвлөгөөний дагуу ихээхэн анхаарал, хүч зарж байсан дэлхийн газрын зураг хийх үйл ажиллагаанд оролцож 1929 оны VIII сар хүртэл суралцсан байна.³ Тэрбээр дараа нь 1932-1933, 1935-1938 оны II сар хүртэл Эрүүлийг Хамгаалах яамны шийдвэрийн дагуу Зөвлөлт Орос Улсын Омск, Москва хотын Анагаах Ухааны Дээд Сургуульд суралцжээ. Мөн 1958 онд Улсын Их Сургуулийн (МУИС) Анагаах ухааны ангийг дүүргэсэн байна.

С.Наваан-Юндэн 1929 онд Герман орноос ирснийхээ дараа Ардыг Гэгээрүүлэх яамны Латин үсгийн зөвлөлд сургагч багшаар ажиллах болсноор ажил, бүтээлийн гараагаа эхэлж, 1931 оноос Улаанбаатар хотын орос дунд сургуульд монгол, хэл бичгийн багш, 1933-1935 онд Эрүүлийг Хамгаалах Төв Больницд ажилтан, Улсын Төв театрт жүжигчин, орчуулагч, 1952-1958 онд Шинжлэх ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, 1958-1961 онд Гадаад Явдлын яаманд Өрнөд хэлтсийн референт, 1961-1966 онд Гадаад Худалдааны яаманд Танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга, 1966-1967 онд БНМАУ-аас БНАГУ-д суугаа Элчин Сайдын яаманд соёлын атташе, 1967-1969 онд БНМАУ-аас БНУАУ-д суугаа Элчин Сайдын яаманд соёлын атташе, 1969-1976 онд БНАГУ-аас БНМАУ-д суугаа Элчин Сайдын яаманд орчуулагч, 1976-1983 онд МУИС-ийн Гадаад хэлний тэнхимд герман хэлний багш зэрэг өндөр хариуцлагатай албуудыг 30 гаруй жил нэр төртэй хашсан байна.⁴

³ Сүлдэт Р.Төрдалай, Монгол-Германы соёл, боловсролын харилцаа: Монгол оюутан, сурагчид Герман улсад суралцсан нь (1926-1930), Герман: Судалгаа, мэдээлэл, УБ, 1(3) 2004, 105-р тал

⁴ Ж. Саруулбуян, Н.Лхамсүрэн, Баатар ван Наваан-Юндэн, УБ, 1994, 94-р тал.

С.Наваан-Юндэн нь зохиолч, хэлмэрч-орчуулагч, дипломатч, судлаач, эмч, багш - сурган хүмүүжүүлэгч хүн байсан төдийгүй хэл шинжлэл, анагаах ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны томоохон бүтээлүүд туурвисан байна.

Тэрээр "Соёл-Эрдэнэ", "Баян Монгол" түүвэр зохиол, олон өгүүлэл, дуу бичиж, дэлхийн уран зохиолын сор болсон бүтээлүүдийг герман, орос хэлнээс эх хэлнээ орчуулж түмний хүртээл болгосон билээ.

С.Наваан-Юндэн нь БНМАУ-ын гадаад харилцааны албанд амьдралынхаа олон жилийг зориулж, манай улсын улс төр, худалдаа, эдийн засаг, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бөгөөд Баруун Европын улсууд ялангуяа Герман, Унгар орныг БНМАУ-тай холбох, эдгээр улсуудтай найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэгдсэн хоёр талын олон гэрээ, хэлэлцээр, уулзалтыг амжилттай өндөрлөхөд бодит хувь нэмрээ оруулсан байна.

С.Наваан-Юндэн багш МУИС-д ажиллах хугацаандаа герман хэлний чадварлаг боловсон хүчин бэлтгэх, герман хэлийг түгээн дэлгэрүүлэх үйлст их хувь нэмэр оруулжээ.

С.Наваан-Юндэнгийн хөдөлмөр, бүтээлийг төрөөс өндөр үнэлж дипломат албаны 50 жилийн ойгоор "Алтан гадас" одон, 50 жилийн ойн медаль, Ардын хувьсгалын ойн медалиуд, жуух бичиг, гадаад, дотоодын олон байгууллагын шагналуудаар тус тус шагнасны зэрэгцээ 1982 онд Зохиолчдын Хорооны шагнал хүртээжээ. С.Наваан-Юндэн 1985 оны XII сарын 29 нд Улаанбаатар хотноо 77 насандаа нас баржээ.

"Герман тагнуулын хэрэг" гэгч зохиомол зүйл бүрэлдэж эхэлсэн нь

XX зууны эхэн хагаст Герман улсыг зорьсон монгол оюутан, сурагчдыг хэлмэгдүүлэх ажиллагаа бүр эрт эхэлжээ. 1928 оны X сарын 23-наас XII сарын 11-ний өдрийг хүртэл хуралдсан МАХН-ын YII их хурлын үр дүнд БНМАУ-ын Засгийн эрхэнд ЗХУ-ын шууд дэмжлэгтэй зүүний хүчин гарч ирлээ. Ингэснээр БНМАУ гадаад бодлогын хоёрдагч түншлэлийн замыг эрэлхийлж өрнөдийн хөгжингүй орнуудтай эдийн

* "Анагаах ухааны нэр томъёоны толь", УБ, 1964, "Орос - Монгол толь", УБ, 1940, "Монгол - Орос толь", УБ, 1957, "Монгол хэлний товч тайлбар толь", УБ, 1970, "Монгол - Орос - Герман хэлний ярианы дэвтэр", УБ, 1981 зэрэг судалгааны ажилд зохиогчоор хамтран оролцож, редактороор ажилласан байна.

засаг, соёл боловсролын салбарт харилцаагаа бэхжүүлэх бодлогоосоо үндсэндээ ухарчээ.

Улмаар баруунтны үед Герман улсын 10-иад хотод төрөл бүрийн мэргэжлээр суралцуулж байсан 40 гаруй оюутан, сурагчдаа эргүүлэн татах ажлыг 1929-1930 онд багтаан шийдвэрлэснээр тэдгээр сурагчид сургуулиа бүрэн дүүргэж чадалгүй буцаж ирсэн байна. Гэвч удалгүй 1932 оны Ү сарын 12-ны орчим Дотоодыг Хамгаалах Газрын дарга Намсрайн тушаалаар Германд суралцсан Д. Нацагдорж, Д. Намдаг нарын зэрэг 12 хүнийг баривчилж, 1932 оны Ү сарын 18-ны өдрөөс Дотоодыг Хамгаалах Нууц Улс төрийн хэлтэс байцаан хорьж эхлэснээр Германд суралцсан оюутан, сурагчид хэлмэгдүүлэлтэд өртөж эхэлжээ.⁵

Тэднийг баривчлан хорьсон гол үндэслэл нь 1932 оны шинэ жилийн баяраар "Манж-го" хэмээх улсын нэг жилийн ойг тэмдэглэсэн", "Берлин Бат-Очирын Дотоодыг Хамгаалах Газарт явуулсан "Тайж Нацагдоржийн банкет" нэртэй гэрэл зураг", "Намдагийн гэрээс олдсон Засгийн газрын тамганы дардас бүхий цэвэр хуудас", түүнчлэн "Д. Намдаг нь майн нэгний өдөр тагнуулын зорилгоор цэргийн зургийг нууцаар авч байсан", "Д. Нацагдоржийг гадаадын тагнуулын байгууллагатай холбоотой ажилладаг"⁶ зэрэг олон зохиомол зүйлүүд байжээ. Эдгээр зохиомол зүйлүүдээр ял тулгаж тэдгээр залуусыг 1932 оны X сарын 19 хүртэл байцаан хорьж хэлмэгдүүлсэн нь ангич онол, үзэл сурталжсан хардалт, сэрдлэгийн хаялга байлаа. Өөрөөр хэлбэл энэ хилс ажиллагааны агуулга, шинж чанараас үзэхэд хожмын Дотоод Явдлын яамны буй болгосон "Герман тагнуулын хэрэг" гэгч зохиомол зүйлийн үндэс суурь энэ үеэс бүрэлдэж эхлээд байсныг тодорхой мэдэж болно.

1930-иад оны сүүл үеэс олон улсын байдал нэн тогтворгүй болж, үзэл суртлаар зааглагдсан шинэ хүчний төвүүд бий болж, олон улсын байдал нэн тогтворгүйжсэн зэргээс шалтгаалан БНМАУ-ын аюулгүй байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдал ЗСБНХУ-аас нягт хамааралтай болсон юм. 1936 оны III сарын 12-нд Монгол-Зөвлөлтийн удирдлагууд 10 жилийн хугацаатай харилцан туслалцах протоколд гарын үсэг зурсан байна.⁷

Олон улсын тогтворгүй байдлаас шалтгаалан БНМАУ-д жил

⁵ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423, 1-р тал

⁶ Мөн тэнд

⁷ БНМАУ-ын гадаад харилцааны баримт, бичгүүдийн эмхтгэл (1921-1961), боть 1, УБ 1964, 288 хуудас

ирэх тутам ЗХУ-ын нөлөө, үзэл суртал хүчтэй болсон, түүнчлэн Герман улсын улс төрийн түгшүүртэй байдал зэргээс улбаалан 10 гаруйхан жилийн өмнө Герман улсад сурагчдаа илгээн суралцуулж, худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоохыг чухалчилж байсан тэрхүү бүлээн үеийг санагдуулах зүйл Монголчуудын дунд бараг үгүй болсон байлаа. Олон улсын харилцааны хурцдмал байдлыг дүгнэн шинжилж 1937 оны X сарын 22-26 хүртэл хуралдсан МАХН-ын Төв Хорооны III Бүгд хурал дээр Х. Чойбалсангийн илтгэлийг сонсоод гаргасан тогтоолын 1-р зүйлд: "Одоо бүх дэлхийн олон улсын байдал улмаар хурцдаж байгаа бөгөөд фашистын засагт Япон, Герман, Итали улсуудын холбоо нь бага буурай улсуудыг дайран довтлох ажлуудыг эмхэлж, тэдний тусгаар тогтносон байдлыг эвдэн устгаж өөрсдийн колони болгохыг эрмэлзэн бүхий"⁸ гэж онцлон тэмдэглэжээ. 1927 оны намын VII их хурлаас эхлэн ЗХУ-ын шууд дэмжлэгтэйгээр зүүнтнүүд удаа дараа албан ёсоор шүүмжилж байсан Герман, Францад сурагчдыг явуулсан асуудлыг энэ үеэс үзэл сурталжуулан дэвэргэж эхлэв. 20-иод оны сүүлээр баруунтны олон удирдагчдыг хөрөнгөтөн улсуудтай түншилсэн хэргээр буруутгахад эл асуудал гол үндэслэлүүдийн нэг болж байсан бол харин хожим олон улсын байдал тогтворгүй болмогц фашизмын эсрэг тэмцлийн бай болж хувирсан юм. Түүнийхээ баталгаа болгон Германд сургуульд явсан сурагчдыг мөрдөх ажлыг Дотоод Явдлын яам 1938 оноос яаравчлан эхлүүлсэн байна.

Ийнхүү Герман оронд хүүхдүүдээ сургуульд явуулсан "томчуул"-ыг хэлмэгдүүлж дууссанахаа дараа сургуульд явсан "бага"-чуудтай үргэлжлүүлэн "тооцоо бодож" эхэлсэн байна. БНМАУ-ын нүд чих болсон Дотоод Явдлын яамны эл ажиллагаа нь манай талын хувьсгалч сонор сэрэмжийн шалгуур үзүүлэлтийг ЗХУ-ын өмнө нотлон харуулахад чиглэгдэж байсан байж болох талтай.

С.Наваан-Юндэнгийн баривчлагдсан шалтгаан, мөрдөн байцаалтын эхний жилүүдийн тухай

С.Наваан-Юндэнг Омск хотын Анагаах Ухааны Дээд Сургуульд суралцаж байх үед буюу 1938 оны II сарын эхээр Москвагаас Улаанбаатар хотноо дуудан ирүүлж, 1938 оны III сарын 23-ны өдөр Дотоодыг Хамгаалах Газраас эх орноосоо урван тэрсэлж, хувьсгалын эсэргүү Японы тагнуулын ажилд оролцож байсан нь баримттайгаар

⁸ МАХН, Их, бага хурал, Төв Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр (1921-1939), боть 1, УБ 1956, 595-р тал.

илэрсэн гэх үндэслэлээр анх дайчлан баривчилжээ.⁹ Мөрдөн байцаалт явуулж зохиомол хэрэгт холбогдуулан шийтгүүлсэн боловч удалгүй мөн оны XI сарын 15-ны өдөр зарим хэргээ бүрэн хүлээгээгүй, нуун дарагдуулсан нь сүүлийн үеийн баримтуудаас тодорхой илэрсэн хэмээн дахин баривчилжээ.¹⁰

Мөрдөн байцаалтын эхний шатанд С.Наваан-Юндэнд Японы тагнуулын байгууллагын гишүүн байсан гэж тулгахыг оролдож байснаа удалгүй Германы тагнуулын байгууллагын идэвхтэн гишүүн болгохоор байцааж эхэлсэн байна. Мөн С.Наваан-Юндэнгээс гадна Герман улсад хамт сургуульд явсан Д. Намдаг, Бавуу, Бат-Очир, Цэвэг, Т. Нацагдорж нарын олон хүнийг баривчилан хорьсон байна. Ялангуяа С.Наваан-Юндэн бага насандаа Баатар вангийн хошууны засаг ноён явсан тул Дотоод Явдлын яам түүнийг ангийн дайсан, феодал гэж үзээд тулгасан хэргээ улам бүр дэвэргэхэд нөлөөлсөн болов уу?.

1938 оны VII сарын 15-ны өдрийн Үнэн сонины № 77 (1552)-д Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Улсын өрлөг жанжин Х. Чойбалсан “Хувьсгалын 17 жилийн ойд хувьсгалын дайснуудыг тэмцэн устгасан түүхт туршлага ба цаашдын үүрэгүүд” гэдэг мэдэгдэл хийсэн нь Дотоод Явдлын яамны мөрдөн байцаагч нарт Япон, Германы тагнуулчдыг илрүүлэн олж устгах ажиллагаанд нь үзэл суртлын суурь болж өгчээ. Тэрээр хэлэхдээ: “... фашизмын дээрэмчний үнэн нүүрийг олон түмнийхээ өмнө илрүүлэн гаргаж тэдгээрийн хорт явуулага хөнөөлийг яруугаар огтчин устгаж дуусгаад товрог болгоход бүрэн нөхцөл буй бөгөөд хэрхэвч тэдэнд мэхлэгдэхэд хүрэхгүй болмой”¹¹ гэж цохон тэмдэглэсэн байна.

Дотоод Явдлын яамны бие бүрэлдэхүүн Герман оронд суралцсан сурагчдыг хилээр хэлмэгдүүлэх ажиллагаа гүнзгийрэхэд энэ мэдэгдэл үзэл суртлын хувьд нөлөөлсөн нь дамжиггүй юм. Үүнтэй холбогдуулан Герман улсад улс төрийн байдал хурцатсан гэдэг үндэслэлээр БНМАУ-д ЗХУ-ын зөвшөөрлөөр худалдааны үйл ажиллагаа явуулж байсан Герман улсын Востваг (Wostwag) компанийг БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1938 оны X сарын 24-ны өдрийн тогтоолыг үндэслэл болгон Сангийн яамны сайд Ю. Цэдэнбалын тушаалаар үйл ажиллагааг зогсоосон

⁹ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423, 113-р тал

¹⁰ Мөн тэнд

¹¹ Х.Чойбалсан, Хувьсгалын 17 жилийн ойд хувьсгалын дайснуудыг тэмцэн устгасан түүхт туршлага ба цаашдын үүрэгүүд, Үнэн, 1938 оны VII сарын 15-ны өдөр, № 77 (1552)

байна.¹² Ингэснээр ЗХУ-ын зөвшөөрлөөр БНМАУ-д үйл ажиллагаагаа явуулж байсан Герман улсын сүүлчийн компанийг БНМАУ-аас шахан гаргасан байна.

Дэлхийн II дайны жилүүдэд Германд суралцсан хүмүүсийг байцаан мөрдөх ажиллагаа эрс ширүүсч, Дотоод Явдлын яамнаас "Герман тагнуулын хэрэг"-ийг зохиомлоор бий болгоод 1941 оны VII сараас чангалан байцааж эхэлсэн байна. С.Наваан-Юндэнг шоронгийн орос, монгол байцаагчид ээлжлэн байцаах болж, Германы тагнуулын байгууллагатай хэдийнээс, хэрхэн холбогдон ажиллаж байсан, хэн хэнтэй хамсаатай болох, ямар ямар ажиллагааг зохион байгуулсан зэрэг зохиомол зүйлээ батлахын тулд хатуу чанд мөрдөн байцааж байсан байна.

Эхний үед С.Наваан-Юндэн "Германы тагнуулын ямар ч байгууллага байгаагүй, тагнуул хийсэн хүний тухай дуулсан, үзсэн харсан зүйл үгүй, бид Герман улсад эрдэм сурахаар явсан. Тагнуул хийхээр яваагүй" гэж чин үнэнээ мэдүүлсээр байсан боловч хэргээ хүлээхгүй нуун дарагдуулсан гэх үндэслэлээр түүнийг улам бүр чангалан байцаах болсон байна.¹³ Зөвхөн "Герман тагнуулын хэрэг"-ээр хэлмэгдсэн хүмүүс ч бус бусад олон иргэд Дотоод Явдлын яамны тарчлаан зовоох байцаалтын хүнд бэрхийг амсаж, зарим нь шоронд амиа алдсан юм.

Жишээ нь 1937 оны IX сарын 10 нд "Ж. Лхүмбийн хэрэг"-т холбогдон баривчлагдсан Б. Ринчин абугайг мөн хувьсгалын эсэргүү, Япон тагнуул гэж хилсээр ял тулган байцааж байжээ. Тэрээр Дотоод Явдлын яамны тамлан зовоолтын улмаас хилсээр хэрэг хүлээж байсан тухайгаа Намын Төв Хорооны Тусгай Комисст хожим бичихдээ: "Миний бие 1937 оны есдүгээр сарын нэгэн шөнө гэнэт баривчлагдаад, Японы тагнуул хийж байсан гэдэг оргүй түмэн хилс хэрэгт тулгагдан байцаагдсан билээ. Ардын хувьсгалт төрийн хууль ёсонд байж үл болох муухай харгис эрүү шүүлт, зодуур нүдүүр, нойр хоолгүй, өдөр шөнөгүй байцаагдан тулгуулж, Японы тагнуулын байгууллагын гишүүн болсон гэж хилс хэрэг хүлээсэн билээ"¹⁴ гэсэн нь тухайн үеийн хилсээр байцаагдаж байсан олон хүн амь мултрах, зарим шийдсэн хэсэг нь бүр зовохгүй түргэн үхэхийн тулд аргагүйн эрхэнд ухаантай ухаангүйн завсар хийгээгүй хэргээ хүлээж байсны нотлогоо юм.

¹² *Үндэсний Төв Архив. Фонд № 359, данс-1, хадгаламжийн нэгж-128, хуудасны дугаар 3*

¹³ *Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423.*

¹⁴ *Г.Дүйнхэржав, Тамын тогоонд таван жил, УБ, 1991, 88-р тал.*

Тухайн үед Дотоод Явдлын яам мөрдөн байцаалт явуулахдаа олон зохисгүй хүч хэрэглэх аргуудыг ашиглаж мэдүүлэг гаргуулж байжээ. Тэдгээрээс заримыг дурьдвал, бусдаас тулгаж албадан гаргуулсан худал мэдүүлгийг хүчээр хүлээлгэх, удаан хугацаагаар хөдөлгөлгүй суулгах, зодох, өлсгөх, карцерт хорьж дааруулах, нойргүй жижүүрлэн байцаах, хурц гэрэл тусган байцаах, сүрдүүлэн айлгах, зохиомол мэдүүлэгт танилцуулахгүйгээр гарын үсэг зуруулах зэрэг бусармаг аргуудыг хэрэглэж байжээ.¹⁵

Хэдийгээр өдгөө бидэнд энэ тухайд тодорхой баримт үгүй боловч С.Наваан-Юндэнг мөрдөн байцаахдаа Дотоод Явдлын яамны орос, монгол мөрдөн байцаагчид дээрхи аргуудаас хэрэглэж байсан нь дамжиггүй юм. Мөрдөн байцаалтын явцад С.Наваан-Юндэн Дотоод Явдлын яамнаас тулгаж байсан хэргийг хүлээхгүй байсан тул Дотоод Явдлын яамнаас гадаадын тагнуулын байгуулалтаар холбоотой ажиллаж, эх орноосоо урван тэрсэлсэн зэрэг үндэслэлээр шийтгэж 1938 онд цаазаар авах ял өгч байсан байна.¹⁶ Гэвч өдгөө энэ шүүх хурлын тухайд холбогдох албан ёсны баримт нотолгоо олдохгүй байна.

С.Наваан-Юндэнгийн цагаатгалын хэрэгт хийсэн судалгааны ажиглалт

Өдгөө Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423 -т хадгалагдаж буй "Даржаагийн Наваан-Юндэнгийн мөрдөн байцаалтын хэрэг" гэсэн гарчигтай 270 хуудас цагаатгалын материалд "Герман тагнуулын хэрэг"-т холбогдуулан С.Наваан-Юндэнг 1941 оны I сарын 20-ноос 1943 оны IX сарын 7 хүртэл мөрдөн байцаасан баримтууд хадгалагдаж байна.¹⁷ Энэхүү мөрдөн байцаалтын хэргүүд нь бүхэлдээ С.Наваан-Юндэн гуайн аргагүй хүчинд автан хилс хэрэг хүлээн мэдүүлж байсан гунигт үеийн түүхийг илтгэх ажээ.

1943 оны Y сарын 19-нөөс өмнөх үеийн түүний мөрдөн байцаалтын материалууд олдохгүй байгаа ч өдгөө бидний үед хадгалагдаж үлдсэн энэхүү эх сурвалжид ажиглалт хийн шинжлэснээр тухайн үеийн түүхэн бодит байдлыг тодруулан сэргээх боломжтой юм.

¹⁵ А.Думбарай, *Залхаан цээрлүүлэлт: Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 1930-1940-иэд онд болсон хэлмэгдүүлэлт*, УБ, 1997, 233-р тал,

¹⁶ Т.Гэндэн, *Гурван түмэн хүний амь*, УБ, 1999, 161-р тал.

¹⁷ *Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423.*

С.Наваан-Юндэнгийн цагаатгалын хэрэг нь 270 хуудастай бөгөөд бүх бичвэр монгол бичгээр байна. Баримт бичиг он цагийн хувьд 1941 оны I сарын 20-ноос 1943 оны IX сарын 7-ныг хамарч байгаа боловч сурвалжийн мэдээлэл өгөх боломж 1938 оны III сарын 23 нд баривчлагдсанаас хойших үеийн үйл явцыг зарим талаар агуулж байна.

Энэхүү эх сурвалжийг агуулагын хувьд авч үзвэл С.Наваан-Юндэнгээс авсан биеийн байцаалт, түүнээс авсан мөрдөн байцаалтууд, хүмүүстэй нүүрэлдүүлж асуусан байцаалтууд, бусад хүмүүсээс С.Наваан-Юндэнгийн тухайд авсан мэдүүлэгүүдээс бүрдэж байна. Мөрдөн байцаалтын явцад зарим мэдүүлэгийг ягаан ба хөх бэхээр таталж бичээд мэдүүлэгийн эх ноорог тус бүрийг нэг хувь машиндаж эхийн хамт ард нь хавсаргасан байна.¹⁸

Түүнчлэн машиндаагүй гар ноорог эх, гар ноорог нь байхгүй машиндсан мэдүүлэгүүд цөөнгүй байна. Машиндсан болон гар ноорог эхүүд нь хоёул хадгалагдаж үлдсэн мөрдөн байцаалтын тэмдэглэлүүдийг жишиж судлах боломжтой бол харин аль нэг эх нь байхгүй нөхцөлд харьцуулах боломжгүй юм. Судалгааны ажиглалтын явцад уг эх сурвалжийн машиндсан текстэд гар ноорог эхт байгаа үндсэн санааг өөрчилж оруулсан зүйл байхгүй байгаа боловч зарим үгийг дарж хассан, нэмж оруулсан, өөрчилсөн зүйлс тааралдаж байна.

Мөрдөн байцаалтын стратеги ба С.Наваан-Юндэнгийн зохиомол мэдүүлгүүдийн тухай

Үндсэндээ С.Наваан-Юндэнгийн мөрдөн байцаалтын уг хэрэгт засалт бага орсон гэж үзэж болохоор байна. Учир нь С.Наваан-Юндэн мөрдөн байцаалтын сүүлийн жилүүдэд хийгээгүй хэргээ зохион худал мэдүүлж, хилс хэрэг биедээ хүлээх болсон тул Дотоод Явдлын яам чангалан байцаахаа больж, Германы тагнуулын байгууллагын идэвхтэй гишүүн болж олон төрлийн гэмт хэргүүдийг хийж байсан зэргээр хариулсан мэдүүлэгүүдийг гаргуулж өөрөөр нь гарын үсэг зуруулж байсантай холбоотой юм. Гэвч түүний гарын үсэг зурж баталсан тэдгээр мэдүүлэгүүд нь хоорондоо уялдаа холбоо муутай, зөрчил зөрөө ихтэй байдаг нь зохиомол зүйл мэдүүлж байсныг гэрчилнэ.¹⁹

¹⁸ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423.

¹⁹ Мөн тэнд

1943 оны Ү сарын 19 нд жинхэнэ байцаагч Чүлтэмийн авсан байцаалтад 1936, 1937 онуудад Германы эсэргүү тагнуулын байгууллагын хурал болсон тухай байдаг бол 1938 оноос эхлэн мэдүүлсэн хэргээ худал зохиосон гэдгээ хүлээн зөвшөөрсөн байдаг.²⁰ Тэрээр худал хэрэг хүлээсэн тухайгаа байцаалтад мэдүүлэхдээ "Миний бие анх 1938 онд байцаагч Жигмэд, Сосоржав нар дээр байцаагдахдаа тэд нараас намайг хууль бус зодож, жанчих буюу элдэв хууль бус аргыг хэрэглэн шахаж шаардсан учраас одоо мартжээ. Үлэмжхэн олон нууц хурлуудыг хийсэн хэмээн худал мэдүүлэгийг гаргасан"²¹ гэх зэргээр оргүй худал мэдүүлж байсан тухайгаа өгүүлсэн байдаг. Хэдийгээр С.Наваан-Юндэн өөрийн худал зохиомол хэрэг хүлээснээ үе үе цухас дурьдаж байсан боловч үндсэндээ Германы тагнуулын байгууллагын гишүүн байсан гэдэг зохиомол мэдүүлгээ өгсөөр байлаа.

Энэ нь ч учир шалтгаантай байсан ба түүнийг хэргээ худал зохион мэдүүлэхэд олон хүчин зүйл нөлөөлж байсан байна. Тэрээр хэргээ үнэн зөвөөр мэдүүлэхэд түүнд ашиггүй байсан нь илэрхий бөгөөд дээр мэдүүлэгт дурьдагдсан Жигмэд, Сосоржав зэрэг байцаагчдын мөрдөн байцаалтын хүнд бэрх байдлаас хөндийрөх гол арга нь худал зохиож мэдүүлэх явдал байжээ. Тийм ч учраас С.Наваан-Юндэн 1943 оны IX сарын 7-ны өдөр Дотоод Явдлын яамны Мөрдөн байцаах хэлтэсийн 3-р группын дарга, капитан Гомбодоржид өгсөн байцаалтдаа "... Наваан-Юндэн миний тагнуулчин байсан илэрхий. Би ерөөс Германы тагнуулчин биш хэмээн хэлэхэд хэн ч үнэмшихгүй"²² гэж өгүүлсэн нь тухайн үеийн бодит байдлыг үнэлсэн түүний үгс юм.

С.Наваан-Юндэнг мөрдөн байцаасан үйл явцтай холбоотой бас нэг сонирхол татсан зүйл бол түүний угсаа язгуурын асуудал байв. Дотоод Явдлын яамны байцаагчид түүнээс 1943 оны VIII сарын 20-ны өдөр авсан байцаалтаа "Феодал Баатар ван хэрэгтэн Наваан-Юндэнг байцаасан тогтоол",²³ мөн оны IX сарын 7-ны өдрийн байцаалтаа "Хуучин Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны ноён явсан тайж феодал язгууртай Даржаагийн хэрэгтэн Наваан-Юндэнд байцаалт явуулсан тогтоол"²⁴ гэх зэргээр нэрлэсэн явдал юм.

²⁰ Мөн тэнд

²¹ Мөн тэнд

²² Мөн тэнд

²³ Мөн тэнд, 26-р тал

²⁴ Мөн тэнд, 55-р тал

Энэ нь Дотоод Явдлын яам С.Наваан-Юндэнг 1913-1921 он хүртэл хуучин Түшээт хан аймгийн Баатар вангийн хошууны засаг ноён явсан, удаан хугацаагаар Герман улсын сургууль, соёлд суралцан хөрөнгөтний үзэл онолоор хүмүүжин хувьсгалт ёсыг үл ойшоон хөрөнгөтний үзэл, онолтой болж хүмүүжсэн, тиймээс эртнээс ардын хувьсгалт нам, засгийн эсрэг хандаж, тус улсын хувьсгалт нам, засгийг устган Монгол улсыг хөрөнгөтний замаар хөгжүүлэх зорилготой Германы тагнуулын байгуулагад элсэж тагнуулын тоог олшруулах зорилгоор уг байгуулагадаа гишүүн элсүүлэх, тагнуулын ажлуудыг үйлдэж явсан гэж хардаж сэрдсэнтэй холбоотой юм.

С.Наваан-Юндэн мөрдөн байцаалтын сүүлчийн жилүүдэд зохиомол мэдүүлэг өгсөөр байсан ч Шүүхийн таслан шийтгэх хурал дээр олон удаа мэдүүлэгээ буцаж байжээ. Жишээлбэл 1943 оноос С.Наваан-Юндэн байцаагдаж байсан нөхдийн адилаар "надад Герман тагнуулын ажил хийж явсан удаагүй. Биеэ гүтгэж худал хэрэг хүлээсэн, Бат-Очир нар ч Германы тагнуулчин бус. Би эд нарыг гүтгэсэн юм, Намайг Дотоод Явдлын яамны Мөрдөн байцаах хэлтсийн ажилчдаас кастерьт хорьсны дараа хэргээ эс хэлбэл дахин 10-20 хоногоор кастерьт суулгана гэж сүрдүүлснээр худал хэрэг хүлээсэн,"²⁵ ерөөс Д. Нацагдоржийнд эсэргүү хурал хийсэн зүйлгүй, Бат-Очирын нүүрдэлгээс болж хүлээсэн юм. 1932 оны XII сарын эцэст шинэ жилийг угтсан будаалга болсноос өөр эсэргүү хурал болоогүй, Аюурзанатай хамт Германаас ирсэн эмэгтэй нь Аюурзанын эхнэр болохоос бус Германы тагнуулчин бус. Сүүлдээ гагцхүү агаар тохирохгүйгээс нутаг буцсан юм, ерөөс Москвад Германы Элчингийн ажилчин Леонардо гэдэг хүн байгаагүй. 1927-1928 онуудад намайг Германы Подстам хотноо сургуульд байхад сургуулийн багш Леонардо* гэдэг нэртэй нэгэн өвгөн байсан тул түүнийг нэрийг барьж худал мэдүүлсэн, Германы тагнуулчин Штейна гэдэг хүн байгаагүй,

²⁵ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423, 55-р тал

* С.Наваан-Юндэн 1927 оны I сараас Берлин хотын Лихтерфельде дүүрэгт орших Улсын Сургалтын байгууллага /Staatliche Lehranstalt in Lichterfelde/-ын дунд сургуульд Б. Бавуу, С. Пүрэвдорж, Доржсүрэн, Б. Содном (том) нарын хамт суралцаж байжээ. Улмаар С.Наваан-Юндэн, Б. Бавуу, Б. Содном нар профессор Леонардогийн гэрт амьдрах болсон байна. Профессор Леонард бол хожим Наваан-Юндэнгийн бичсэнчлэн: "Эртний нэртэй багш, ололонхүүхдийг халамжлан сургаж хүмүүжүүлсэн магтан сайшаавал зохих хүн байсан төдийгүй тэднийг эрдэм боловсролтой сайн хүн болоосой гэж үнэн голоосоо хүсдэг, үнэтэй зөвлөгөө сургаалыг хэлж заадаг хүн" байжээ. /С.Наваан-Юндэн., Соёл эрдэнэ, Түүвэр зохиол, Улаанбаатар, 1976, 250-251-р тал/

санаанаас зохиож худал мэдүүлсэн²⁶ гэх зэргээр худал хэрэг хүлээж байснаа үнэнээр залруулан мэдүүлж байсан байна.

С.Наваан-Юндэнгийн цагаатгалын хэргээс үзэхэд түүний баривчилагдсан 1938 оны III сарын 23-ны өдрөөс эхлэн эхний жилүүдэд Дотоод Явдлын яамны байцаагч Жигмэд, Сосоржав нар дээр анх байцаагдаж байгаад Шүүхийн таслан шийтгэх хурлын шийдвэрээр түүний хэргийг (Энэ тухай цагаатгалын хэрэгт он, сар, өдрийг тодорхой тэмдэглээгүй байна. Р. Т.) дахин мөрдөхөөр Улсын Мөрдөн Байцаах Газрын мэдэлд шилжүүлсэн бололтой байна.²⁷

Харин 1941 оны I сарын 20-ноос эхлэн 1943 оны XII сарын 14 нд хэргээ шүүхээр таслан шийтгүүлэх хүртэл Мөрдөн Байцаах хэлтэсийн 3-р группын дарга, капитан Гомбодорж, 6-р группын дарга моёор Цогзол, жинхэнэ байцаагч Чүлтэм, Базарсад, Пүрэв, Мижидсүрэн, Сэрээнэн, Түвдэнжав зэрэг байцаагчид С.Наваан-Юндэнг мөрдөн байцааж байжээ.²⁸ Мөн 1941 оны X сарын 16-ны өдрийн түүний мөрдөн байцаалтанд Дотоод Явдлын яамны сайд, гуравдугаар комиссар Шагдаржав байлцсан байна. С.Наваан-Юндэнг "Герман тагнуулын" гэх уг хэрэгт холбогдуулан хэдэн удаа байцаасан нь тодорхойгүй байгаа бөгөөд учир нь түүний 1941 оны I сараас өмнөх байцаалтууд энэхүү цагаатгалын хэрэгт багтаж ороогүй байна.

С.Наваан-Юндэнг уг хэргийн дагуу Герман улсад хүүхэд ахуй насандаа хамт сургуульд явж суралцсан тухайн үед Улсын Төв театрт найруулагчааражиллаж байсанд. Намдаг, Шинжлэх ухааны хүрээлэнгийн Гэрэл зургийн тасгийн эрхлэгчээр ажиллаж байсан "шилэн" Гомбожав, мөн Бат-Очир, Гомбо, Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажилтан С.Цэвэг, Комбинатын ажилтан Бадарчин, Кино зургийн хороонд ажилтай байсан "бага" хэмээх Т.Нацагдорж нартай нүүрэлдүүлэн байцаалт авч байжээ.

Энд онцлон тэмдэглэхэд, С.Наваан-Юндэнгийн мэдүүлэгүүд их зөрчил, зөрөөтэй байгаа явдал болно. Жишээлбэл "... Наваан-Юндэн миний бие 1929 онд Германы тагнуулын газраас тагнуулын даалгаврыг авхагдаа юуны өмнө тус Монгол улсын хувьсгалт нам, засгийг устган улмаар хуучны феодалын засгийг байгуулахын тулд Монгол улсыг Зөвлөлт Холбоот Орос Улсын холбооноос салгаж хөрөнгөтөн улсыг түшиглүүлэн ирээдүйд хөрөнгөтний замаар хөгжүүлэх ийм зорилтыг

²⁶ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423, 58-70-р талууд

²⁷ Мөн тэнд, 56-р тал

²⁸ Мөн тэнд, 9, 28, 136, 137, 139, 141, 153, 162, 164-р талууд

тавьж орсон юм"²⁹ гэж мэдүүлсэн боловч энэхүү мэдүүлэг нь маш ерөнхий шинжтэй үндэслэл баталгаа, нотлогоо муутай байгаагийн дээр сүүлд өгсөн мэдүүлэгүүд нь уг санаагаа давтсан боловч зөрчилтэй төдийгүй үндэслэлтэй батлахуйц нэг ч баримтгүй зохиомол зүйлс болох нь тодорхой байна. С.Наваан-Юндэн 1943 он ... сарын ... өдрийн байцаалтандаа "... Би Германы тагнуулчид Их Нацагдоржоор элсэгдэж, Содномыг элсүүлснээс бус Бат-Очир нартай харилцаатайгаар тагнуулын ажлаа явуулж байгаагүй" гэж мэдүүлж байсан бол 1943 оны IX сарын 7-ны өдрийн мэдүүлэгтээ "... Наваан-Юндэн би 1931 оны XI сард Их Нацагдоржийнд болсон тагнуулын ажлаа сайжруулах тухайн эсэргүү хурал зөвлөгөөнөөс хойшид Нацагдоржийн хэлснийг баримтлан Бат-Очирт тагнуулын мэдээ материалаа хураалгаж байсан, мөн "... 1932 онд Омск хотноо Хүн Эмнэлэгийн Дээд Сургуульд очихдоо Содномтой Алтанбулагт уулзаад өөрөө сургуульд явж буйгаа мэдэгдэхийн хамтад Содномын ажиллах зоригийг нэмэгдүүлэхийн тулд Улаанбаатар хотноо манай Германы тагнуулын ажилд бидэнтэй хамт Германд явсан Цэвэг, Бавуу нарын зэрэг хүмүүс нэмэгдэж, манай хүчин улам бүр хөгжин бэхжиж байгаа. Үүнээс хойшид Их Нацагдоржтой харилцаж ажиллах хэрэгтэй гэсэн заавар өгөөд явсан дахиж уулзаагүй" гэх буюу "Их Нацагдорж 1932 оны эхээр баригдаад асар удаагүй мөн оны VIII сарын үесээр суллагдсан. Намайг IX сард Омскт явахад шоронгоос аль хэдийнээ гарсан байсан юм"³⁰ гэж мэдүүлж байсан боловч түүхийн баримт сэлтийг мөшгин үзвэл Д. Нацагдорж нь шоронд хоригдож байсан 1932 оны VIII сарын 15 нд бичсэн нэгэн захидалдаа " Өдгөө гянданд суун бие тэсэхүйеэ болж буйн" учрыг гаргаад хийсэн хэрэггүй "хилсээр хоригдон буй болох тул даруй хэрийг цагаатган өршөөлийг үзүүлмүү" гэж мэдүүлснээр удалгүй 1 жилийн тэнсэн харгалзах ялтайгаар Д.Намдагийн хамт 1932 оны X сарын 29 нд суллагдсан байна.³¹ Иймээс С.Наваан-Юндэнгийн дээрхи мэдүүлэг нь зохиомол зүйл байсан нь түүхийн баримтаар тодорхой нотлогдож байна.

Түүнчлэн С.Наваан-Юндэнг БНМАУ-д үйл ажиллагаа явуулж байсан Германы "Востваг" эрхлэгч Дайны хамт тагнуулын ажиллагаа явуулж байсан гэж Дотоод Явдлын яам үзэж байсан боловч энэ тухай албан ёсны ямар ч баталгаа тэдэнд байгаагүй бололтой байна. С.Наваан-Юндэнгээс зохион мэдүүлэхдээ тагнуулын харилцаатай

²⁹ Монгол улсын Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив, Фонд № 1, хадгаламжийн нэгж- Ц 423, 58-р хуудас

³⁰ Мөн тэнд

³¹ А.Очир, Г.Дашням, Д.Нацагдорж: Нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал, Улаанбаатар 1996, 165-р тал

байсан гэж мэдүүлсэн Штейна, Леонардо гэх нэрс нь цем санаанаас зохиосон зүйлүүд байсан ба ерөөс тийм хүмүүс байгаагүй гэдгээ Шүүхийн таслан шийтгэх хурал дээр С.Наваан-Юндэн хэргээ буцаж үнэнээр мэдүүлэхдээ баталсан байдаг.

Энэхүү түүхэн эх сурвалжийг судлах явцад Дотоод Явдлын яамны мөрдөн байцаагчдын байцаалтын асуултуудад шинжилгээ хийж ажиглахад мөрдөн байцаалтын концепци, төлөвлөгөөний чиглэл нь С.Наваан-Юндэнг мэдүүлэгээ нуун дарагдуулсан, дутуу, эсвэл худал мэдүүлснийг шалгах, тулгаж буй хэргүүдээ хүлээлгэж батлуулах, хэргээ буцсан шалтгааныг тодруулах, мэдээлэл цуглуулах, зөрчил илрүүлэх тандалтын асуултуудаар дамжиж гагцхүү "фашист Германы тагнуул, гадаадын эзэрхэг түрэмгий фашист улсын шууд тусламжаар Монгол Ардын Хувьсгалт Нам, Засгийн газрыг унагаах зорилго бүхий эх орноосоо урвасан хувьсгалын эсэргүү тагнуулын газрын идэвхтэй гишүүн" гэдэг хатуу байр суурь баримталж байсан ч энэ нь гагцхүү байцаагдаж буй С.Наваан-Юндэнгийн зохиомол мэдүүлэг дээр үндэслэгдэж байсан бөгөөд мэдүүлэгт шинээр оруулж ирсэн баталгаатай баримт, мэдээ байхгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ нь Дотоод Явдлын яамны байцаагчдад С.Наваан-Юндэнг Германы тагнуул байсан гэж нотлох албан ёсны ямар ч баримтгүй байсныг нотолж байна.

Ийнхүү зохиомол хэрэг хүчинд автан хүлээн мэдүүлсээр С.Наваан-Юндэн 1943 оны XII сарын 28-ны өдрийн Дотоодын Явдлын Явдлын Тусгай Комиссын 14-р тогтоолоор хэрэг нь таслагдаж 10 жилийн хорих ял авч хэлмэгдсэн байна.³²

С.Наваан-Юндэн 1950 оны III сард 2 жилийн тэнсэн харгалзах ялтайгаар суллагдсан байна. Тэрээр "Герман тагнуулын хэрэг" гэгч зохиомол зүйлд холбогдон 12 жил ял эдэлж авъяас билигтэй энэ хүний амьдралын алтан мөчүүдийг Дотоод Явдлын яамны үзэл суртлын хийрхэл амьдралаас нь булаан авчээ.

Өдгөө архивийн баримт материалыг сөхөн харахад "Герман тагнуулын хэрэг"-г холбогдон хэлмэгдсэн хүмүүсийн Дотоод Явдлын яаманд өгсөн мэдүүлэгүүд хоорондоо их зөрүүтэй, албан ёсны нотлогоогүй байдаг ба зарим ахмад судлаачдын мэдээлж байгаагаар уг хэрэг олон удаа задарсны зэрэгцээ шалгалтын явцад Германы Аюулаас Хамгаалах байгуулагаар шалгуулахад бодитой баримт илэрсэнгүй"³³ байна.

³² УАБХГ-ын 1997 оны Ү сарын 03-ны 10/731 тоот архивын лавлагаа

³³ Т.Гэндэн, Гурван түмэн хүний амь, Улаанбаатар, 1999, 161-р тал

С.Наваан-Юндэнг 1958 оны X сарын 24-ны Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Цагаатгах Ажлын Комиссын 12-р тогтоолоор цагаатгаж, улс төрийн хэрэгт хилсээр шийтгэгдсэн хэмээн нэр төрийг нь албан ёсоор сэргээжээ.³⁴

Ийнхүү олон жилийн туршид хөрөнгөтөн, фашизмтай тэмцэх тэмцлийн гол бай болж байсан "Германы тагнуулын хэрэг" гэгч нь С.Наваан-Юндэн зэрэг олон хүний амьдралыг хэлмэгдүүлснээр дууссан бөгөөд энэхүү зохиомол хэрэг нь тухайн үеийн БНМАУ-ын түүхэн нөхцөл, ЗХУ-аас БНМАУ-ын талаар баримталж байсан улс төрийн бодлого, түүнээс улбаалсан үзэл суртлын хийрхэлтэй нягт уялдаатайгаар бий болсон байна. Иймээс эл асуудлыг гүнзгийрүүлэн судлах нь социалист нийгэмд шилжихээс өмнөх зурвас үеийн БНМАУ-ын нийгмийн байдлыг судлахад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Өгүүллийг бичигчийн зүгээс эцэст нь тэмдэглэхэд, Германд суралцсан бусад залуусын уг хилс хэрэгт холбогдож хэлмэгдсэн тухай судалгааг өргөн хүрээг хамруулан явуулах шаардлагатай байгааг дурьдахын зэрэгцээ өдгөө энэ талаар судалгаа тун чамлалттай байгааг зориуд тэмдэглэе.

³⁴ Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комиссын дэргэдэх Хэлмэгдэгсэдийн Судалгааны Төвөөс авсан мэдээлэл